# Аймгийн АДХ—ын 7 дахь удаагийн 3 дугаар чуулганд БНМАУ-ын Ардын Их Хурлын 6 дахь удаагийн анхдугаар чуулганы шийдвэрийг биелүүлэх арга хэмжээний тухай

## Аймгийн АДХГ Захиргааны дарга, депутат Ц. Жамсрангийн тавьсан илтгэл

*Үргэлжлэл*

Үүнтэй уялдуулан байнгын комиссын хурал хийх, цугларах явдлыг чуулган хүлээж суух биш аймгийн байнгын комиссын гишүүд бол жилдээ 2, сумынх ажлынхаа шаардлагаар цуглардаг байх. Үүнд: зардлыг нь депутатын ажилладаг газруудаас олгож байх хэрэгтэй юм. Байнгын комиссын ажлын голыг байгууллагын үйл ажиллагаанд төрийн хяналт тавих, аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, нам, засгийн тогтоол шийдвэр, хуулийн биелэлтийг шалгах ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, ажлын арга барилыг сайжруулах, тэргүүн туршлага нэвтрүүлэхэд идэвхтэй туслахад чиглүүлэх хэрэгтэй.

Ингэхийн тулд байнгын комиссын хурлаар зохих байгууллага, албан тушаалтны илтгэл, сонсголыг тодорхой асуудлаар тогтмол сонсож, тэдэнд зохих үүрэг даалгавар өгч ажилд нь туслалцаа үзүүлэх хэрэгтэй юм.

Ардын депутатуудын хурал болон байнгын комиссын тавьсан асуудлын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтан тодорхой арга хэмжээ авч байхын хамт тэдгээр хүмүүст шаардлагатай чухал мэдээ баримтыг цаг тухайд нь гарган өгч байх үүргийг биелүүлэх хэрэгтэй. Хөдөлмөрчдийн сайн дурын олон нийтийн байгууллагын ролийг дээшлүүлэх, ажил төрлийн холбоо уялдааг сайжруулах, тэднийг өөрсдийн дүрмэнд заасан үүргээ биелүүлэхэд нь дөхөмийг үзүүлэх зорилгоор АДХ—ын асуудал эрхэлсэн байнгын комисс удирдлаг болгохоор заасан Ардын Их Хурлын удирдамжийг үндэслэн, тэдний үүргийг тогтоож, дор дурьдсанаар хамааруулах саналыг оруулж байна.

Үүнд:

1. Соёл гэгээрлийн байнгын комисст
—насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс
—Сургууль албан газрын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, хороо
—Уран сайхан ба клубын дэргэдэх зөвлөл
—Сурган хүмүүжүүлэх зөвлөл
—Сэхээтний зөвлөл
—Эмэгтэйчүүдийн зөвлөл

2. Хууль ёс, хэв журмыг сахиулах байнгын комисст.
—Олон нийтийн шүүх
—Цагдан сэргийлэхэд туслах хамт олны бригад
—Захиргааны комисс

3. Хот тохижуулах байнгын комисст.
—Гудамж орон сууцны хороо, зөвлөл
—Субботникийн товчоо

4. Эрүүлийг хамгаалах байнгын комисст.
—Улаан загалмайн нийгэмлэг
—Биеийн тамирын зөвлөл
—Ариун цэврийн комисс, байцаагчид
—Арга маягийн зөвлөл

5. ХАА—н байнгын комисст.
—ХАА—г удирдах газрын дэргэдэх мэргэжилтний зөвлөл
—Нэгдлүүдийн бригадын зөвлөл
—Социалист хөдөлмөрийн ба төлөө бригад

6. Барилгын байнгын комисст
—Барилгын зөвлөл

7. Худалдаа үйлчилгээ, үйлдвэрийн комисст.
—Дэлгүүрийн комисс

8. Төлөвлөгөө төсвийн байнгын комисст.
—Эдийн засгийн зөвлөл
—Шинэ санаачлагын комисс

Эдгээр комиссууд ажлын төлөвлөгөө боловсруулах, илтгэл сонсгол авах, шалгалт явуулах асуудлыг боловсруулахад хамтран ажиллаж, харилцан биесийн ажилд туслах, ингэснээрээ давхардах чирэгдэл гаргахыг багасгаж, асуудлыг тал бүрээс нь нягт боловсруулж шуурхай цэгцтэй явуулахад хамгийн дөхөмтэй болох болно.

Олон түмнийг төрийн ажилд татан оролцуулахад бас нэг чухал хэлбэр бол байнгын комиссын ажлыг өргөн далайцтай болгох үндсийг бүрдүүлсэн төрөл бүрийн мэргэжилтэн, туршлага дадлагатай идэвхтэн тэргүүний хүмүүсийг байнгын комиссын идэвхтнээр бүртгэн авч ажиллуулах асуудлыг өргөн болгож, аймгийн хурлын байнгын комисс бүр 20—оос доошгүй, сум, хороодын байнгын комисс 7—10 идэвхтэнтэй байж, байнгын комиссууд нь ажил төрлийн онцлогоор өөрийн гишүүдийг дотор нь секц болгон хувааж болох юм.

Тэр секц нь 3-аас цөөнгүй депутат, 5—аас доошгүй идэвхтэнтэй байх нь зүйтэй гэж үзэж байна.

Байнгын комиссын хариуцлагыг өндөржүүлэхдээ холбогдуулан аймаг сум, хороодын ээлжит чуулган бүр дээр нэг байнгын комиссын тайлан илтгэл, мөн хэлэлцэгдэж байгаа асуудалд холбогдох байнгын комиссын хавсралт илтгэлүүдийг ээлж дараатай тавиулан, ажлыг нь дүгнэх, түүнчлэн байнгын комиссын гишүүд хийсэн ажлынхаа талаар хөдөлмөрчид, үйлдвэр, албан байгууллагын хамт олны өмнө хагас жилд нэг удаа сонсгол тавьж байх нь чухал.

Байнгын комисс нь сард нэг албан үйлдвэрийн газрын илтгэлийг сонсч, 2—оос доошгүй газар, хүмүүсийн ажилд шалгалт явуулж, депутатын танхимд сард 2 удаагаас цөөнгүй цугларч ажлаа зөвлөж байх нь депутатын хэсгийг САА, ХАА-н нэгдлийн бригад тасагт аймаг, сумын депутатын хамтарсан бүрэлдүүнтэй байгуулах, энэ хэсгийг 3—аас дээш депутаттай газар байгуулах бөгөөд тэр бригад, тасаг дээр төрийн хяналт тавьж байх хэрэгтэй.

Байнгын комиссын гишүүдийн үүрэг хариуцлага, эрхлэх ажлыг олон нийтийн төлөөлөгчид, байгууллага, олон төрлийн комиссуудтай нягт уялдаатай байлгах санаачлага идэвхийлэл гаргаж, тэргүүн сайн ажилласан байнгын комиссын идэвхтэнд сайшаал урамшил үзүүлж байх хэрэгтэй.

### АРДЫН ДЕПУТАТЫН РОЛИЙГ БҮХИЙ Л ТАЛААР ӨНДӨРЖҮҮЛЬЕ

Депутатын ролийг бүхий л талаар дээшлүүлж, сонгогчдын өмнө тэдний хүлээх хариуцлагыг өндөржүүлэх явдал намаас төрийн талаар тавьж байгаа бодлого, Ардын Их Хурлын чуулганы заалтыг биелүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолгой. Одоо манай аймагт ардын хурлын аймаг, сум, хорооны депутат 973 байна.

Эдгээр бол тус аймгийн амьдралын чухал асуудлыг зохион байгуулахад их хүч юм.

Ийм учраас юуны урьд депутатын үйл ажиллагаар идэвхжүүлэх, түүний нэр хүнд эрхийг өндөрт өргөх явдал чухал юм.

БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганд н. Дүгэрсүрэн тавьсан илтгэлдээ: «Депутатууд чуулганы шийдвэрийг хөдөлмөрчдөд тайлбарлан таниулах, уг шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулахад биечлэн идэвхтэй оролцох үүрэгтэй юм.

Депутатуудын тавьсан аливаа асуудалд төрийн ба олон нийтийн байгууллага, албан тушаалтан бүхэн анхааралтай хандаж, хөнгөн шуурхай ажил хэрэгчээр биелүүлэх үүрэгтэй байна. Депутатын тавьсан асуудал, санал шаардлагад хайнга хандах, үл ойшоах, бэрхшээл шалтгаан тоочих зэргээр хүнд суртал гаргах үзэгдэлтэй эрс шийдвэртэй тэмцэж, зохих арга хэмжээ авч байх хэрэгтэй» гэжээ.

Депутатын үйл ажиллагааны нэг чухал хэлбэр бол депутат бүхэн тойргийнхоо сонгогчидтой уулзалт хийхээс гадна сонгогчдыг хүлээн авч эрэлт хүсэлтийг сонсч, түүнд хариу өгөх явдлыг хангах ёстой.

Энэ талаар БНМАУ-ын Ардын Их Хурлын 1964 оны тогтоол ёсоор хот, хорооны ардын депутат 14 хоногт, сумын депутат, сонгогдсон тойрогтоо ажилладаг аймгийн депутат сард нэг удаа, тойргийнхоо гадна ажилладаг аймгийн хурлын депутат улиралд нэг удаа эрэлт хүсэлт судлах журмыг заавал биелүүлэх, депутатууд тайлангаа сонгогчдын өмнө жилд заавал тавьж байхын зэрэгцээгээр зарим депутатын үйл ажиллагааг чуулганд сонсож байх нь зүйтэй юм.

Депутатын үүргээ биелүүлэхэд нь гүйцэтгэх захиргаа, улс, олон нийтийн байгууллага анхаарал тавьж, идэвхтэй тусламж үзүүлж байвал зохино.

Депутат хүн сонгогчидтойгоо уулзахдаа холбогдох байгууллагын удирдах нөхдийг байлцуулан, хөдөлмөрчдөөс тавьсан асуудлын талаар тэдний саналыг сонсч байх хэрэгтэй.

Бүх шатны депутатуудаас улсын аппаратын ажлын хариуцлага, сахилга батыг бэхжүүлэхтэй холбогдуулан депутатын асуулгыг хөгжүүлэх, депутатын шаардлаганд хариуцлагагүй хөшүүн хойрго ханддагийг илрүүлэн арга хэмжээ авч депутатын асуулга шаардлагын нэр хүндийг эрс дээшлүүлэх хэрэгтэй.

Депутатуудыг төрийн байгууллагын ажлын арга барилд сургаж дадлагажуулах, тэдэнд төрийн байгуулалтын үндсийг системтэй судлуулах, төр эрхийн мэдлэгийг өндөр байлгахад аймаг, сум, хороодын гүйцэтгэх захиргаад ихээхэн анхаарал тавих ёстой.

Үүнтэй уялдуулан ард түмний соёлын сургуулийн дэргэд төр эрхийн факультетийг аймгийн төв Жаргалант суманд байгуулахаар төлөвлөж байна.

Төв суурин газарт оршин суудаг депутат бүхэн хөдөлмөрчдийг хүлээн авдаг газартай болох (өөрийн ба бусдын орон гэр, албан газрын тасалгаа, депутатын танхим хаа ч болно) харин хэзээ хаа хүлээн авч байх тухай нарийн тогтоосон цагийн хувиартай байх нь чухал юм.

Нөгөө талаар депутат бүхэн депутатын танхимдаа сард нэг удаа (чуулганы чөлөө цагт) орж ажилладаг, хөдөлмөрчдийн эрэлт хүсэлт хүлээн авах газар биеэр суудаг байх, мөн хөдөлмөрчдийн эрэлт хүсэлт, гомдол саналыг гэр, байр, ажлын газраар нь явж судалж арга хэмжээ авахуулж байх хэрэгтэй юм.

Сум, хороодын депутатын өдөрлөгийг сар бүрийн 27-нд явуулж байхыг цаашид бататгаж, депутатыг ажлын аргад сургах, сургууль болгох хэрэгтэй.

Ардын депутат бол хөдөлмөрчин олон түмний төлөөлөгч бөгөөд хамгийн хүндтэй хүн мөн. Ийм учраас тэднийг үсчин, халуун ус, кино, клуб, улаан булан, үзвэрийн газар, нийтийн хоолны газар зэрэг нийгэм хангамж, соёл үйлчилгээний газруудад очер дугааргүй тэргүүн ээлжинд үйлчилж байх явдлыг хангах, нийтийн хоолны газар, кино, ардын клуб, уншлагын газруудад депутатын ширээ суудал, эмнэлэг, буудлын газарт депутатын өрөө тасалгааг байнга байлгаж байх арга хэмжээг аймаг, сум, хороод дээр авах нь зүйтэй гэж үзэж байна. Депутатыг ажил үүргээ гүйцэтгэхэд тухайн дэвсгэр нутаг дээр нь үнэ төлбөргүй уналгаар хангаж байх нь зүйтэй гэж үзэж байна.

Аймаг, сумын депутатыг тусгай бланк бүхий дэвтэртэй болгож, тэднээс албан үйлдвэрийн газарт тавих шаардлагаа албан ёсоор бичиж тавьдаг болгох хэрэгтэй байна.

Тэр шаардлагыг хүлээн авсан газар, хугацаа тогтоон авч албан ёсоор хариулдаг байх хэрэгтэй.

Байнгын комисс, депутатын роль ихээхэн өндөржиж, тэднээс олон түмний дотор ажиллах шаардлага өсч байгаа нь ажлын арга барилаа ямагт баяжуулан нэмэгдүүлж байхыг шаардаж байна.

Энэ асуудалтай холбогдуулан депутат, байнгын комисс бүхэн дүрмээ ширхэгчлэн биелүүлэх, өөрсдийн ба зэргэлдээ сумууд, бусад аймгийн АДХ-ын байнгын комиссын тэргүүний ажиллагааг судлан танилцах, ЗХУ-ын зөвлөлүүдийн ба бусад социалист орон, түүний байнгын комисс, депутатын үйл ажиллагаанаас сурах ажлыг маш өргөн зохиож явуулах хэрэгтэй.

Байнгын комисс, депутатуудаас гүйцэтгэх захиргаадад асуудлыг боловсруулан оруулах, гүйцэтгэх захиргаад, олон нийтийн байгууллагын хуралд суулцаж саналаа өгч байх заншилтай болгох хэрэгтэй.

*(Үргэлжлэл нь 4 дүгээр нүүрт)*

# Аймгийн АДХ—ын 7 дахь удаагийн 3 дугаар чуулганд БНМАУ—ын Ардын Их Хурлын 6 дахь удаагийн анхдугаар чуулганы шийдвэрийг биелүүлэх арга хэмжээний тухай

## Аймгийн АДХГ Захиргааны дарга, депутат Ц. Жамсрангийн тавьсан илтгэл

*(Үргэлжлэл)*

### ХУРЛУУДЫН ЧУУЛГАН БОЛ ИХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ УЧИР РОЛЬ ҮҮРЭГ НЬ ӨНДӨР БАЙХ ЁСТОЙ

Хурлуудын чуулганаар хэлэлцэх асуудлыг ихээхэн өргөтгөж, түүнд улс ардын аж ахуй, соёлын чухал чухал асуудлыг оруулж байх, чуулганы биелэлтийг сайн хангасны үндсэн дээр шуурхай чанартай хийдэг болгох хэрэгтэй.

Чуулганы бэлтгэл ажилд депутат, байнгын комисс, хэлэлцэх асуудалд холбогдол бүхий байгууллага, мэргэжилтэн, хамт олон, олон нийтийн төлөөлөгчдийг идэвхтэй оролцуулах, өргөн далайцтай ажил зохиож байх хэрэгтэй.

Чуулганд асуудал оруулж хэлэлцүүлэх байгууллагын санаачлага хариуцлагыг эрс өндөржүүлэх нь чухал байна.

Чуулганд урьдах чуулганы шийдвэрийн биелэлтийг заавал сонсч байх зарчмыг хатуу мөрдөхөөс гадна уул чуулганы шийдвэр, санал шүүмжлэлийн мөрөөр ажиллах, төлөвлөгөөг нарийн сайн боловсруулж, ажил болгож байх хэрэгтэй. Чуулганы шийдвэрийг хөдөлмөрчдөд таниулах талаар тодорхой ажил зохиож, биелэлтийн явцыг хөдөлмөрчдөд мэдэгдэж байх хэрэгтэй.

Намын 15 дугаар их хурал, Ардын Их Хурлын чуулганы шийдвэрийг биелүүлэхэд сум, хороодын захиргааны роль үүрэг ихээхэн өсч, шаардлага нь улам өндөржлөө.

н. Цэдэнбал: Намын 15 дугаар их хурлын шийдвэрийн үндсэн дээр төрийн аппаратын ажлыг эрс сайжруулах, түүний үйл ажиллагааг нарийн эмх цэгцтэй гавшгай шуурхай болгох, аппаратын хэсэг бүхэн дээр хатуу сахилга бат, зохион байгуулалттай байлгах, ноогдсон үүрэгт ажлын талаар ажилтан бүрийн хариуцлагыг дээшлүүлэх нь чухал, дутагдалтай өвлөрөх явдал гаргахгүй байхаар ажлаа зохиох, гаргасан шийдвэрийг биелүүлээгүй хүмүүст хатуу шаардлага тавьж, холбогдох арга хэмжээ авах, ажилтан нарыг ажлаа нягт, нямбай хичээнгүй гүйцэтгэдэг болгох, ажил төрлийн мэргэжил, үзэл суртал, улс төрийн хэмжээг нь дээшлүүлэх, салан задгай, эмх замбараагүй байдал, ажлын хариуцлага алдах явдлын илрэлтэй эрс тэмцэх хэрэгтэй байна гэснийг төрийн захиргааны аппарат онцгой анхаарч ажиллах ёстой.

Гүйцэтгэх захиргаадаас зохих шатны депутат, байнгын комисстой ажлаа нягт холбон тэдний ажилд туслах, чуулган ба хөдөлмөрчдийн өмнө жил тутам тайлагнаж, ард түмний дүгнэлт шүүмжлэлийг сонсч, ажлын арга дадлагыг сайжруулан засч байх хэрэгтэй.

Сум, хороодын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны дотоод ажлыг улам тодорхой болгон, нэр хүнд, ач холбогдлыг дээшлүүлэх, аж ахуй. соёлын төлөвлөгөөт ажлыг биелүүлэхэд хариуцлага, хяналтыг сайжруулах, захиргааны ажлын аргыг түйлын боловсронгуй болгох явдал үнэхээр өндөрт тавигдаж байна.

Сум, хороодын дотоод зохион байгуулалтын ажлын талаар аймгийн АДХГ Захиргааны 1966 оны I дүгээр сард гаргасан тогтоолын заалтыг тууштай биелүүлэх хэрэгтэй байна.

Аймгийн АДХГ Захиргааны газар хэлтсийн ажлыг шуурхай далайцтай болгох,тэднээс аймгийн гүйцэтгэх захиргааны өмнө хариуцах хариуцлагыг ба сум, харъяа байгууллагад тавих шаардлагыг шинэ шатанд гарган сайжруулах хэрэгтэй.

Аймгийн АДХГ Захиргааны газар, хэлтсүүд хөдөлмөрчдөд нийтэд нь ба хэсэгчилж, мөн харъяа газрынхаа аппаратын өмнө тайлагнаж байх журмыг нэвтрүүлэх хэрэгтэй.

Депутат, байнгын комисс, сум, хороодын АДХГ захиргаа, газар, хэлтсүүдээс хөдөлмөрчдөд тайланчилах асуудлыг ор нэр болгох, ёс төдий хандах явдлаас болгоомжилбол зохино.

Социалист төрийн хөгжих зүй тогтоолын дагуу захиргааны эрхлэн хариуцаж байгаа асуудал аажмаар олон түмний өөртөө засах байгууллагад шилжиж байх жамтай.

Төрийн аппаратыг хямд төсөр байлгах асуудлыг тууштай явуулах, төр, аж ахуйгаа удирдах хэрэгт олон түмнийг бүтээлчээр оролцуулахын тулд аймаг, сумын гүйцэтгэх захиргаадад орон тооны бус хэлтэс, зохион байгуулах группийг байгуулан ажиллах явдал ач холбогдолтой гэж үзэж байна.

Үүнтэй холбогдуулан аймгийн ардын депутатын хурлын гүйцэтгэх захиргаанд хууль дүрмийн биелэлтэнд хяналт тавих хэлтэс, сум хороодод хууль дүрмийн биелэлтэнд хяналт тавих хэсэг байгуулж, орон тооны биш орлогч даргаар толгойлуулах, Зуунмод хотод нийтийн үйлчилгээ хангамж эрхэлсэн орлогч,Жаргалант, Батсүмбэр, Баянчандманий тосгонд ариун цэвэр, эх нялхасын хэсгийг байгуулж, орон тооны хэлтэс, тасгийн эрх мэдэлтэй ажиллуулж болох юм гэж үзэж байна.

Нийтийн орон сууц ихээхэн өсч байгааг харгалзан бүх сум, хороодын төвд орон сууцны зөвлөлийг байгуулж ажиллах, орон тооны бус эдгээр хэлтэс, хэсэг зөвлөл бол сум, хороо, аймгийн ардын депутатын хурлын байнгын комисстой ажлаа холбоотой явуулах ёстой бөгөөд тэдгээрийг нэр хүндтэй байгууллага болгон өсөхөд аймаг сум, хороодын АДХГ Захиргаад их анхаарах ёстой.

Хөдөлмөрчин ард түмний чирэгдлийг багасгах зорилгоор САА, нэгдлийн бригад, фермийн бригад дарга нарт засаг захиргааны ажлыг хамааруулахаар БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлөөс тогтоосонтой холбогдуулан тэдний эрхлэх ажлыг орон нутгийн нөхцөл шаардлаганд зохицуулан үүргийг тодотгон тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.

Үүнд: тухайн дэвсгэр нутаг дээр оршин сууж байгаа хүн ам, мал хөрөнгийн тооллого бүртгэл, иргэдийн төрөлт, нас баралт, татвар хураамж, олон хүүхэдтэй эхчүүдэд тэтгэврийг дамжуулан олгох, иргэдийн соёл боловсрол, эрүүл мэндийг хамгаалах, ариун цэвэр, хүн, малын халдварт өвчинтэй тэмцэх, гал, усны аюултай тэмцэх, билчээр ба ой модыг арчлан хамгаалж, ариг гамтай ашиглах, улсын хөрөнгийг арчлах хамгаалах, хэзээд эзэнтэй байлгах асуудал, улсын бэлтгэлийн биелэлтэнд хяналг тавих, хөдөлмөрчдийн эрэлт хүсэлтийг барагдуулахад оролцох ба дээрхи асуудалтай холбогдох мэдээ бүртгэл гаргах зэрэг шаардагдах асуудлыг харнуцуулах нь зүйтэй юм.

Депутатын танхим бол депутат, байнгын комисс болон төрийн хурлын байгууллагат чухал газар юм.

Аймаг, сум, хот, хороодын депутатын танхимыг депутат, байнгын комиссын ажиллах жинхэнэ төв болгож, ардын депутатуудын боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, байнгын комиссуудын хуралдаж цуглараx, депутатуудаас хөдөлмөрчидтэй уулзах, олон түмэнд төрийн хуулийг сурталчлах төв болгох хэрэгтэй.

Депутатын танхимын бүрэлдэхүүнийг засаг төрийн зохион байгуулалтыг бүрэн харуулсан самбар, зураг плакад, лавлах ширээ, хууль дүрмүүд, депутат, байнгын комиссын туршлагаар бүрдүүлэн засагдсан цаг үеийн байдлаар өөрчлөгдөн шинэчлэгдэж байх хэрэгтэй.

Депутатын танхимыг одоо хүртэл байгуулаагүй байгаа Их хайрхан, Тарнат, Архуст, Өндөрширээт сумд, Зуунмод хотын гүйцэтгэх захиргаад 8 дугаар сарын дотор багтаан байгуулахыг эдгээр сумдын дарга нарт шаардах хэрэгтэй байна.

Цаашид депутатын танхимыг нэг байлгаж, нэг буулгаж байх биш өдөр тутмын тогтмол ажиллагаатай, түүнд сум, хороодын захиргааны гишүүд, депутат, орон тооны бус аппарат ээлжлэн ажилладаг болговол зохино.

Төрийн захиргааны байгууллагын хүмүүжүүлэх нөлөөг улам хүчтэй болгохын хамт нтгүүлэх, албадах аргыг нягт хослуулах, ажлын дутагдлаас урьдчилан сэргийлэхэд анхаарал тавивал зохино гэсэн Ардын Их Хурлын чуулганы заалтыг тус аймгийн төрийн байгууллагууд удирдлага болгох ёстой.

### НӨХӨД ӨӨ!

Төрийн захиргааны байгууллагын гол гүйцэтгэх үүрэг бол улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөг биелүүлэх явдал мөн юм.

Нам, засгаас авч явуулж байгаа зүйл бүрийн арга хэмжээ хөдөлмөрчдийн идэвхтэй шаргуу хөдөлмөрийн үрээр тус аймаг сүүлийн жилүүдэд нилээд амжилт олсон юм.

Гэвч 1966 оны эхний хагас жилийн ажил ихээхэн доод хэмжээнд явагдаж, аймгийн чуулганаар баталсан график зөрчигдөж байна.

1966 оны эхний хагаст Сэлэнгэ аймагтай байгуулсан уралдаанаа манай аймаг алдлаа.

Улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөний хувьд ч гол гол үзүүлэлт өнгөрсөн оны мөн үеэс нилээд ажил доогуур байна.

Эхний хагас жилийн ажлаас дүгнэлт хийж аймгийн Намын Хороо, Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаа хөдөлмөрчиддөө захидал бичиж ажил сайжруулах 3 сарын өндөр бүтээлийн аяныг зохиосон юм.

Энэ тогтоолыг манай орон нутгийн нөхөд олон түмэн сайшаан хүлээж авлаа.

Үүний үр дүнд одоогийн байдлаар зарим ажилд ахиц гарч байгаа юм.

Гэхдээ Статистикийн товчоноос гаргасан мэдээнээс үзвэл 8 дугаар сарын 1—ний байдлаар аймгийн хэмжээгээр төрөл бүрийн ноос 432,5 тонн, сүү 9369,0 мянган литр, цөцгийн тосноос 71,3 тонн, мал махнаас 439 тонн, агт бэлтгэл 1,7 мянга дутуу байна.

Барилгын үйлдвэрлэлийн явц тун удаашралтай, Үйлдвэрийн Хоршоолол, Авто баазын хөрөнгийн эргэлт дорой байна.

Гэтэл эдгээр газрын удирдах нөхөд аймгийн Намын Хороо, АДХГ Захиргаанаас үзүүлж байгаа туслалцааг хариуцлагагүй ашиглаж байна. Тариа ногоо хураах бэлтгэл ажил, ялангуяа техник засвар зарим станц, САА—д удаашралтай байна.

Хадлан авахад бэлтгэлтэй гэж байгаа боловч хадах талбайгаа олоогүй сумд ч байна.

Мал таргалуулалт, мал хээлтүүлгийн ажилд бас их дутагдал оршнж байна.

Аж ахуйн гэрээг Худалдаа бэлтгэлийг удирдах газар бараг бүх газартай хийсэнгүй, чуулганы заалтыг хөсөрдүүлж байна.

Бас энэ гэрээг байгуулсан зарим газрууд дээр ор нэрийн төдий болсныг хэлэх хэрэгтэй.

Энэ талаар арбиторийн байгууллага анхаарах хэрэгтэй.

Өвлийн бэлтгэл, ялангуяа нүүрс таталтын ажил Зуунмод хотын нилээд албан газарт бас л хангалтгүй явагдаж байна.

Улсын төсвийн орлогын биелэлт ч тун хангалтгүй байна.

Энэ нь аймгийн Худалдаа бэлтгэлийг удирдах газар, Хоршоолол, Хэвлэх үйлдвэрүүд, зарим сумд хөрөнгийн эргэлтийг сайжруулах, орлого хуримтлалыг нэмэгдүүлэх талаар муу анхаарч байгаатай холбоотой юм.

Манай ажлын доголдол тасалдал бол чухамдаа удирдах ажилтны ажлын хариуцлага, сахилга батаас шалтгаалж, голдуу сум, хороодын АДХГ Захиргаад түүний гишүүдтэй холбоотой байна.

Энэ нь их бага яаз бүрийн ажил дээр илэрч байна. Асуудалд төрийн захиргааны байр сууринаас биш ганц хоёр байгууллага, хүний эрх ашгийн үүднээс хандах, төвлөн удирдах ёс зарчимыг үл хайхран дур зоригоор авирлаж ажил хохироох, хууль дүрэм зөрчиж, ажилд хальт мульт хандах, үр бүтээлгүй суусаар цаг хугацаа алдах явдал манай зарим сум, хороодын удирдах нөхдөд дээр амь бөхтэй зууралдаж байгааг цаашид тэвчиж болохгүй.

Барилгыг ажиллах хүчнээр хангах асуудал нэн чухал байна.

Аймгийн Намын Хороо, АДХГ Захиргаа зарим арга хэмжээ авсан юм. Гэтэл Баянца-

(Төгсгөл нь 5 дугаар нүүрт)

*Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!*

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

*Төв аймгийн намын хороо, АДХ Гүйцэтгэх захиргааны сонин.*

19 дэх жилдээ №60 (1557) | 1966 оны 8 дугаар сарын 12 | БААСАН

## Намынхаа шийдвэрт зориглсон саальчин

Алтанбулаг сумын аварга саальчин Оросоо гуай МАХН—ын 15 дугаар их хуралд төлөөлөгчөөр оролцсон ХАА—н тэргүүний сайчуудын нэгээ. Оросоо гуай намын 15 дугаар их хурлын шийдвэрийг хөдөлмөрчдөд сурталчлан таниулж байна.

Одоогийн байдлаар 6 газар уулзалт, 9 удаа сонсгол яриа хийж, 20 гаруй айлаар явж бүгд 900 шахам хөдөлмөрчдийг хамран сурталчилжээ. Оросоо гуай нутгийн үүлдрийн үнээнээс 800 литр сүү саахаар социалист уралдаанд үүрэг авч ажиллажээ.

Бас саалийн бус цагаар 1 тонн өвс, 300 кг витаминт тэжээл бэлтгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

*Г. Нямбуу*

# СОНСГОЛ МЭДЭЭ

Аймгийн АДХ—ын 7 дахь удаагийн 3 дугаар чуулган 1966 оны 8 дугаар сарын 5—ны өдөр Зуунмод хотод болов.

Чуулганд «БНМАУ—ын Ардын Их Хурлын 6 дахь удаагийн анхдугаар чуулганы шийдвэрийг биелүүлэх арга хэмжээний» тухай 48 дугаар тойргийн депутат, АДХГ Захиргааны дарга Ц.Жамсрангийн илтгэлийг хэлэлцэв.

53 дугаар тойргийн депутат Д. Аръяа, Баянцогт сумын АДХГ Захиргааны дарга Х.Чойжилжав, 44 дүгээр тойргийн депутат У.Доржпалам, 31 дүгээр тойргийн депутат Х.Билгээ нар илтгэлтэй холбогдуулж үг хэлж, санал тавилаа. Чуулганаар БНМАУ—ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газрын шалгалтад бэлтгэж, орон нутгийн АДХ тэдгээрийн гүйцэтгэх байгууллагуудын ажлыг сайжруулах, депутат, байнгын комиссын ажлын талаар зохиох ажлын төлөвлөгөө батлав.

Мөн төлөвлөгөөг биелүүлэх, чуулганд тавигдсан илтгэлд заагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, сум, хороодын Гүйцэтгэх Захиргаадад даалгасан тогтоол гаргав.

Аймгийн АДХ—ыг сонгох сонгуулийн 38 дугаар тойргийн депутатаар Шагдарын Агваансодовыг нөхөн сонгосон тухай мандатын комиссын илтгэлийг депутатууд санал нэгтэй батлав. Аймгийн АДХГ Захиргааны гишүүн Б.Дэжид, Х.Сэтэв нар өөр газар шилжсэн тул Гүйцэтгэх Захиргааны гишүүнээс чөлөөлж 38 дугаар тойргийн депутат Ш.Агваансодов, 79 дүгээр тойргийн депутат Ч.Дашдэмбэрэл нарыг Гүйцэтгэх Захиргааны гишүүнээр сонгоод, Х.Сэтэвийг аймгийн Гүйцэтгэх Захиргааны орлогч даргын үүрэгт ажлаас чөлөөлж Ч.Дашдэмбэрэлийг Гүйцэтгэх Захиргааны орлогч даргаар батлав.

Тус чуулган аймгийн АДХ—ын байнгын комиссуудыг 9 болгон өргөтгөж байгуулаад ХАА, бэлтгэл эрхэлсэн байнгын комиссын даргаар 67 дугаар тойргийн депутат О.Лхамсүрэн, соёл гэгээрлийн байнгын комиссын даргаар 31 дүгээр тойргийн депутат Х.Билгээ, Тээвэр холбооны байнгын комиссын даргаар 75 дугаар тойргийн депутат Д.Товуу, Барилгын асуудал эрхэлсэн байнгын комиссын даргаар 26 дугаар тойргийн депутат Ж.Мөнхтогоо, Үйлдвэр худалдаа, үйлчилгээний байнгын комиссын даргаар 24 дүгээр тойргийн депутат Р.Чимэдцэрэн, Эрүүлийг хамгаалах байнгын комиссын даргаар 39 дүгээр тойргийн депутат Н.Мөнхөө, Хууль ёс, хэв журмын байнгын комиссын даргаар 71 дүгээр тойргийн депутат Б.Доржсүрэн, хот суурин газрыг тохижуулах, нийгэм хангамжийн байнгын комиссын даргаар 15 дугаар тойргийн депутат Л. Дүгэрсүрэн, төлөвлөгөө санхүүгийн байнгын комиссын даргаар 4 дүгээр тойргийн депутат Ч.Батаа нарыг батлав.

Мөн чуулганаар аймгийн шүүхийн гишүүн нүүдлийн шүүгч Ц.Дарамбазар. Б.Дандар нарыг чөлөөлж, П.Чүлтэм, Д.Шонхор нарыг аймгийн Шүүхийн гишүүн, нүүдлийн шүүгчээр батлав. Аймгийн АДХГ Захиргаанд орон тооны биш хуулийн биелэлт шалгах хэлтэс байгуулж, хэлтсийн даргаар н.Оюундайг батлав. Чуулганаар аймгийн АДХГ Захиргааны усны аж ахуйн хэлтэс, хөдөлмөрийн товчооны дүрмүүдийг батлав. Аймгийн АДХ—ын чуулганы ажиллагаанд БНМАУ—ын Ардын Их Хурлын Тэргүүлэгч гишүүн Д.Ядамсүрэн оролцож дэлгэрэнгүй үг хэлэв.

## Аймгийн АДХ—ын 7 дахь удаагийн 3 дугаар чуулганд БНМАУ—ын Ардын Их Хурлын 6 дахь удаагийн анхдугаар чуулганы шийдвэрийг биелүүлэх арга хэмжээний тухай

### Аймгийн АДХГ Захиргааны дарга, депутат Ц.Жамсрангийн тавьсан илтгэл

ДЕПУТАТ НӨХӨД ӨӨ!

Тус чуулган маш онцлог үед хуралдаж байна. МАХН—ын 15 дугаар их хурал манай намын программыг батлаж, БНМАУ—ыг хөгжүүлэх IV таван жилийн төлөвлөгөөний удирдамжийг гаргалаа. Энхрий хайрт намын 15 дугаар их хурлын түүхт шийдвэрийг биелүүлэх явдал манай нам, улс, аж ахуй, соёл, олон нийтийн бүх байгууллага, бүх хөдөлмөрчдийн хамгийн эрхэм чухал зорилт болон тавигдаж байна. Энэ том зорилтыг биелүүлэхэд манай засаг төрийн байгууллага ихээхэн рольтой юмаа.

Саяхан болж өнгөрсөн БНМАУ—ын Ардын Их Хурлын 6 дахь удаагийн анхдугаар чуулганаар намаас төрийн талаар дэвшүүлэн тавьсан зорилтыг биелүүлэх тухай асуудал хэлэлцэж, чухал шийдвэр гаргаад манай засаг төрийн дээд байгууллагыг шинээр сонгон байгууллаа. БНМАУ—ын Ардын Их Хурлын чуулганы шийдвэрийг биелүүлэхэд аймгийн АДХ-ын одоогийн чуулганы анхаарал чиглэгдэж байна.

ДЕПУТАТ НӨХӨД ӨӨ!

Манай засаг төрийн байгууллага бол монголын ард түмний хувьсгалт их ололт мөн. Засаг төрийн байгууллагын ажлыг бүх талаар сайжруулах явдлыг манай орны хөгжлийн өнөөгийн өрнүүн ололт амжилт, цаашдын их зорилт зүй ёсоор шаардаж байна. Намын 15 дугаар их хурлын тогтоолд заахдаа:

«Социалист байгуулалт гүнзгийрэх тутам засаг төрийн байгууллагын аж ахуй зохион байгуулалт, соёл хүмүүжлийн үүрэг хэлбэрэлтгүй өссөөр байгааг их хурал тэмдэглэж байна» гэжээ. Засаг төрийн байгууллага бол шинэ нийгэм байгуулах, нийгмийн үйлдвэрлэлийг зохион байгуулах, шинэ соёлыг хөгжүүлэх хүчит зэвсэг бөгөөд хөдөлмөрчдийг хүмүүжүүлэх, тэдний социалист ухамсар, сахилга бат, зохион байгуулалтыг дээшлүүлэх чухал арга хэрэглүүр мөн.

МАХН—ы 15 дугаар их хурлын түүхэн шийдвэр, намын шинэ программ, улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх IV таван жилийн төлөвлөгөөний удирдамжинд заасан зорилт нь манай төрийн байгууллагын өмнө урьд урьдаас үлэмж их өндөр хариуцлагатай үүргүүдийг дэвшүүлэн тавилаа. Ийм учраас манай орны хөдөлмөрчдийг хамгийн өргөн хэмжээгээр хамарсан төрийн байгууллага, ардын депутатуудын хурлын ролийг улам дээшлүүлж, цаашид ажлыг нь сайжруулах явдал чухал ач холбогдолтой боллоо.

БНМАУ—ын Ардын Их Хурлын чуулган, намын программ, шинэ таван жилийн төлөвлөгөөний зорилтыг амжилттай шийдвэрлэхэд манай орны бүх хөдөлмөрчид, нам, улс, олон нийтийн бүх байгууллагын бүтээлч санаачлага, идэвхтэй ажиллагаа, их чармайлт шаардагдана гэдгийг заагаад, төрийн бүх шатны хурлуудын ажиллагааг сайжруулж, чуулганыг тогтмолжуулж, түүнд хэлэлцэх асуудлын ажил хэргийн чанарыг дээшлүүлэх, ардын депутатын хурлын байнгын комиссын үүргийг өндөржүүлэн, хариуцлагыг тодорхой болгохын чухлаас үндэслэж, Ардын Их Хурлын байнгын комиссыг 10 болгож нэмэгдүүлснээс гадна байнгын комиссуудын ажиллах бололцоог сайжруулахын тулд Ардын Их Хурлын байнгын комиссын гишүүдийг жилд 2—3 долоо хоног, аймаг, сумын АДХ—ын байнгын комиссын гишүүдийг 1—2 долоо хоногоор үндсэн ажлаас чөлөөлж байх ба байнгын комиссууд, үйлдвэр, аж ахуйн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, улс ардын аж ахуйн төлөвлөгөөг биелүүлэх, тогтоол шийдвэрийн биелэлтийг шалгах, улсын сахилга бат, ажлын хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр албан газрын илтгэлийг тогтмол сонсож заалт гаргаж байх, байнгын комиссын гишүүд нь өөрийн хийсэн ажлын талаар хөдөлмөрчдийн өмнө илтгэл сонсгол тавьж байх, байнгын комиссын заасан асуудалд байгууллага, хүмүүс оновчтой тодорхой арга хэмжээ авч байх хариуцлагыг өндөр болгов.

Ардын хурлын депутатуудын нэр хүнд ролийг дээшлүүлэх, депутатууд чуулганыхаа шийдвэрийн биелэлтийг хариуцаж байх, сумын АДХГ Захиргааны роль хариуцлагыг дээшлүүлэн, тэдний ажлыг боловсронгуй шуурхай болгох, аймаг, сумын АДХГ Захиргаа, тэдгээрийн газар хэлтсүүд, хөдөлмөрчдийн өмнө тайлагнаж байх, төрийн аппаратын ажилтны улс төр, эдийн засаг эрхийн мэдлэг, ажил хэргийн дадлагыг дээшлүүлж, сахилга батыг улам сайжруулахын хамт төрийн аппаратын албан хаагчдаас ажилдаа зарчимч, нямбай хандах хүмүүжлийг нь дээшлүүлэх, орон тооны биш аппарат хөдөлмөрчдийн сайн дурын байгууллагыг олшруулан, ажиллагааг нь идэвхжүүлэх, социалист хууль ёсыг бэхжүүлэх, олон нийтийн хэв журам, дэглэмийг нарийн чанд сахиж биелүүлэх талаар шинэ шинэ чухал арга хэмжээг зааж тогтоолоо.

Эдгээр удирдамжийг шуурхай ажил болгох явдал та бидний өмнө тавигдаж байна.

Аймгийн АДХГ Захиргаа (Булган аймгийн Гүйцэтгэх Захиргаанаас тогтоол шийдвэртээ гүйцэтгэлийн шалгалт хэрхэн зохиож байгаа тухай), (Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Гүйцэтгэх Захиргааны ажлын тухай) БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлөөс 1965, 1966 онд гаргасан тогтоолуудыг биелүүлэх чиглэлээр нилээд арга хэмжээ авч явуулсан. Үүнд: төрийн захир

*(Үргэлжлэл нь 2 дугаар нүүрт)*

